

2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 4 ДҮГЭЭР АНГИ ДЭВШИХ “МОНГОЛ ХЭЛ” ХИЧЭЭЛИЙН ДААЛГАВРЫН БЛЮПРИНТ

2024.06.03

АНГИ, СУДЛАГДАХУУН		4 ДҮГЭЭР АНГИ, МОНГОЛ ХЭЛ								Нийт	Эзлэх хувь
ШАЛГАЛТ ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА		40 МИНУТ									
ДААЛГАВРЫН ХЭЛБЭР		СОНГОХ ДААЛГАВАР				ЗАДГАЙ ДААЛГАВАР					
Үнэлгээний нэгж	Суралцахуйн зорилт	Мэдлэг ойлголт	Чадвар	Хэрэглээ	Бүгд	Мэдлэг ойлголт	Чадвар	Хэрэглээ	Бүгд		
Уншсанаа ойлгох	4.1а. Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс олж, агуулгыг ойлгох		1/1		1/1					1/1	33%
	4.1б. Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	1/1	1/1		2/2		2/1		2/1	4/3	
	4.1в. Уншсан эх, үлгэр, өгүүллэгийн бүтцийн хэсгүүдийн учир шалтгааныг тайлбарлах	1/1			1/1					1/1	
Зөв бичих Зохион найруулж бичих	4.2а. Дуудлага ижил зарим үгийг утга, бичлэгээр нь ялгах, өгүүлбэрт зөв бичих. \буурь -буйр\		1/1		1/1					1/1	
	4.2б. Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэх, зөв бичих						3/1		3/1	3/1	
	4.2в. ж, ч, ш-ийн дараа “и” бичдэгийн учрыг мэдэх, зөв бичих	1/1			1/1					1/1	
	4.2г. Хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэх, зөв бичих	1/1			1/1					1/1	
	4.2и. Хүндэтгэлийн үг хэрэглэн, бүтцийн дагуу урилга бичих							5/1	5/1	5/1	

Зохион найруулж бичих	4.4а. Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох		1/1		1/1		2/1		2/1	3/2	33%
	4.4в. Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох	1/1			1/1		2/1		2/1	3/2	
	4.4г. Эх, өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэх		1/1		1/1					1/1	
НИЙТ ДААЛГАВРЫН ТОО, ОНОО		5/5	5/5		10/10		9/4	5/1	14/5	24/15	
ОНООНЫ ЭЗЛЭХ ХУВЬ		50%	50%		100%		60%	40%	100%		

ОНООНЫ ХЭВИЙН ТАРХАЛТ

Үнэлгэний зорилт	Даалгаврын тоо	Даалгаврын оноо	Даалгаврын эзлэх хувь	Онооны эзлэх хувь
Мэдлэг ойлголт/ Ойлгох/	5	5	33.3	21
Чадвар/ Хэрэглэх/	9	14	60	58
Хэрэглээ/ Задлан шинжлэх/	1	5	6.7	21
Нийт	15	24	100%	100%

ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВРЫН ХАРИУ, ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний зорилт	А хувилбар	Б хувилбар	Оноо	Онооны тайлбар
1. СОНГОХ ДААЛГАВАР						
1	4.1б. Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	СД- Мэдлэг	Б	В	1	Зөв хариултыг сонгосон бол 1 оноо
2	4.1в Уншсан эх, үлгэр, өгүүллэгийн бүтцийн хэсгүүдийн учир шалтгааныг тайлбарлах	СД-Мэдлэг	А	Г	1	Зөв хариултыг сонгосон бол 1 оноо
3	4.1а. Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс олж, агуулгыг ойлгох	СД- Чадвар	В	А	1	Зөв хариултыг сонгосон бол 1 оноо
4	4.1б. Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	СД- Чадвар	А	Б	1	Зөв хариултыг сонгосон бол 1 оноо
5	4.2а. Дуудлага ижил зарим үгийг утга, бичлэгээр нь ялгах, өгүүлбэрт зөв бичих. \буурь - буйр\	СД- Чадвар	В	Г	1	Зөв хариултыг сонгосон бол 1 оноо
6	4.4в Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох	СД-Мэдлэг	А	А	1	Зөв хариултыг сонгосон бол 1 оноо
7	4.2в. ж, ч, ш-ийн дараа “и” бичдэгийн учрыг мэдэх, зөв бичих	СД-Мэдлэг	А	В	1	Зөв хариултыг сонгосон бол 1 оноо
8	4.2г Хатуу зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэж , зөв бичих	СД-Мэдлэг	А	Б	1	Зөв хариултыг сонгосон бол 1 оноо

9	4.4а. Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох	СД-Чадвар	А	Б	1	Зөв хариултыг сонгосон бол 1 оноо
10	4.4г. Эх, өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэх	СД- Чадвар	В	Б	1	Зөв хариултыг сонгосон бол 1 оноо
2.ЗАДГАЙ ДААЛГАВАР						
1.	4.4в Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох	ЗД – Чадвар	Сайн нөхөр-дайсан	Анд нөхөр-найз	2	Эсрэг /ойролцоо/ утгатай үгийг зөв бичсэн бол тус бүр 1 оноо
2.	4.2а. Дуудлага ижил зарим үгийг утга, бичлэгээр нь ялгах, өгүүлбэрт зөв бичих. \буурь - буйр\	ЗД-чадвар	Өөрийн бодол санаа бичсэн байх, түүнийгээ тайлбарласан байна.		2	Өөрийн бодол санаа бичсэн бол-1 оноо, түүнийгээ тайлбарлан бичсэн бол-1 оноо /нийт 2 оноо/
3	4.1и Уншсан зохиолынхоо баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодох	ЗД- Чадвар	А.ХАДАН, ЭРГЭЛДЭН, ОЛОН Б.ОЛОН,ЭНЭ,ХААН		3	1 үгээ зөв сонгож бичсэн бол-1 оноо 2 үгээ зөв сонгож бичсэн бол-2 оноо 3 үгээ зөв сонгож бичсэн бол-3 оноо
4.	4.4а. Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох	ЗД-Чадвар	1-Б 2-А	1-А 2-Б	2	Хоёуланг нь зөв холбосон бол 2 оноо Аль нэгийг холбоогүй бол-1 оноо Огт холбоогүй бол-0 оноо
5.	4.2.д Үйл явдлыг өрнүүлэн, утгын холбоотой богиноэх,өгүүллэг зохион бичих	ЗД-Хэрэглээ	Эхээ бичсэн бол		5	Догол мөр гаргасан,бүтцийн дагуу бол- 5 оноо Догол мөрөөс бичээгүй,бүтцийн дауу бичсэн бол -4 оноо Зөв бичгийн дүрэм алдсан үгнээс 0.1 оноо хасна. Үгийн тоо дутуу,хэтрүүлсэн бол -0,5 оноо



ЗАХИРАГ Ж.БОЛОРМАА

2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 4 ДҮГЭЭР АНГИЙН “МОНГОЛ ХЭЛ” ХИЧЭЭЛИЙН АНГИ
ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

А ХУВИЛБАР

..... сургуулийн 4.... ангийн сурагч

ХУГАЦАА 40 МИНУТ

НИЙТ ОНОО-24

Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй.
Сонгох даалгавар бүр 1 оноотой.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР

Сайхан сэтгэл

Бүргэдийн ангаахай үүрнээсээ толгойгоо цухуйлган хадан хясааны доогуур эргэлдэн нисэж байгаа олон шувууг ажиглажээ.

-Ээжээ, энэ юун олон шувуу вэ? гэж ангаахай асуув.

-Бидний анд нөхөд байна. Бүргэд ганцаараа амьдардаг шувуу. Гэхдээ хааяа тэдэнд найз нөхөд хэрэгтэй. Тэгэхгүй бол бүргэд юуных нь шувуудын хаан байх билээ. Чиний харж байгаа бүх шувууд бидний анд нөхөд гэж ээж бүргэд ангаахайдаа хэллээ. Ээжийнхээ хэлсэн үгийг ангаахай сайтар бодоод тэднийг анд нөхдөө гэж санах болов. Тэгснээ гэнэт чарлаж:

-Хүүе, тэд нар манай хоолыг хулгайлж байна гэв.

-Тайвшир даа. Үр минь, тэд биднээс юу ч хулгайлаагүй. Би тэднийг өөрөө дайлсан юм. Бүргэд өөрөө хэчнээн өлсөж байлаа ч дэргэдээ байгаа шувуутай хоолоо хувааж иддэг жамтай. Ийм өндөрт байгаа шувууд хоол олж идэхэд хэцүү тул бие биеэ дэмжиж тусалдаг юм гэжээ. Үнэнч сайн нөхөдтэй байя гэж бодсон хэн ч бусдын гачигдлыг анхаарч байх хэрэгтэй юм.

1. Ангаахай үүрнээсээ толгойгоо цухуйлган юу олж харсан бэ? /1оноо/
А. өөр нэг ангаахай Б. олон шувуу В. бүргэд Г. найзуудаа
2. Бүргэдийг шувуудын хаан гэж хэлсний учир юу вэ? /1оноо/
А. найз нөхөд ихтэй Б. хоолоо бусад шувуунд алдсан
В. ганцаараа амьдардаг Г.бусад шувууд айдаг
3. Үнэнч сайн нөхөдтэй байя гэж бодсон хэн ч бусдын **гачигдлыг** анхаарч байх хэрэгтэй юм. Тодруулсан үгэнд тохирох үгийг олоорой. /1оноо/
А.ядууг Б. зовлон В. дутагдал Г. жаргал
4. “Ийм өндөрт байгаа шувууд хоол олж идэхэд хэцүү тул бие биеэ дэмжиж тусалдаг юм гэжээ” өгүүлбэрээс юуны тухай ойлгож бэ? /1 оноо/
А. сайхан сэтгэл Б. эхийн хайр В. амиа хичээсэн Г. зан чанар
5. “Буурь” гэдэг үгийн утгыг зөв тайлбарласан хэсгийг олоорой /1оноо/
А. нуур Б.эр тэмээ В. гэр байсан ором Г. буйр
6. ”Дэмжих” гэдэг үгийн ойролцоо утгатай үгийг олоорой. /1 оноо/
А. тэтгэх Б. нэмэгдүүлэх В. өргөх Г.нэмэх
7. “**Балчир**” гэдэг үгтэй ижил дүрмээр бичигдсэн үгийг олоорой. /1 оноо/
А. амжилт Б. анги В. зэхэж Г. сахиж
8. “**Байя**” үгэнд тохирохыг сонгоорой. /1 оноо/
А. Эгшиг болон зөөлний тэмдгээр тогссон үгэнд Я,Ё шууд залгана.
Б. Гийгүүлэгчээр төгссөн үгэнд Я,Ё шууд залгана.
В. Эгшиг болон зөөлний тэмдгээр тогссон үгэнд Е шууд залгана.
9. ”Бүргэд бидний анд нөхөд ганцаараа амьдардаг шувуу ” гэсэн өгүүлбэрт тохирох холбоосыг тэмдэглээрэй. /1 оноо/
А. ба Б. харин
В. үүнээс болж Г.цаашилбал
10. “Тэгснээ гэнэт чарлаж : Хүүе, тэд нар манай хоолыг **хулгайлж** байна гэв.” Тодруулсан үгэнд тохирох хэлц үгийг сонгоорой. /1 оноо/
А. хаяагаа хадрах б. хумслах В. хаяанд ирэх Г. хулгай авах



2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 4 ДҮГЭЭР АНГИЙН **МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН**
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

Б ХУВИЛБАР

..... сургуулийн 4.... ангийн сурагч

ХУГАЦАА 40 МИНУТ

НИЙТ ОНОО -24

Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй. Сонгох даалгавар бүр 1 оноотой.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР

Сайхан сэтгэл

Бүргэдийн ангаахай үүрнээсээ толгойгоо цухуйлган хадан хясааны доогуур эргэлдэн нисэж байгаа олон шувуу ажиглажээ.

-Ээжээ, энэ юун олон шувуу вэ? гэж ангаахай асуув.

-Бидний анд нөхөд байна. Бүргэд ганцаараа амьдардаг шувуу. Гэхдээ хааяа тэдэнд найз нөхөд хэрэгтэй. Тэгэхгүй бол бүргэд юуных нь шувуудын хаан байх билээ. Чиний харж байгаа бүх шувууд бидний анд нөхөд гэж ээж бүргэд ангаахайдаа хэллээ. Ээжийнхээ хэлсэн үгийг ангаахай сайтар бодоод тэднийг анд нөхдөө гэж санах болов. Тэгснээ гэнэт чарлаж:

-Хүүе, тэд нар манай хоолыг хулгайлж байна гэв.

-Тайвшир даа. Үр минь, тэд биднээс юу ч хулгайлаагүй. Би тэднийг өөрөө дайлсан юм. Бүргэд өөрөө хэчнээн өлсөж байлаа ч дэргэдээ байгаа шувуутай хоолоо хувааж иддэг жамтай. Ийм өндөрт байгаа шувууд хоол олж идэхэд хэцүү тул бие биеэ дэмжиж тусалдаг юм гэжээ. Үнэнч сайн нөхөдтэй байя гэж бодсон хэн ч бусдын гачигдлыг анхаарч байх хэрэгтэй юм.

- 1.Ээжээ энэ юун олон шувуу вэ? гэж ангаахайг асуухад бүргэд юу гэж хариулсан бэ? /1 оноо/
А.олон шувуу Б. бидэнтэй адил бүргэд В.бидний анд нөхөр Г.шувуудын хаан
2. “Ээжийнхээ хэлсэн үгийг ангаахай сайтар бодоод тэднийг анд нөхдөө гэж санах болов.” гэсэн өгүүлбэрээс юуны тухай ойлгосон бэ? /1оноо/
А. зан чанар Б. эхийн хайр В. амиа хичээсэн Г. сайхан сэтгэл
- 3.Бүргэд өөрөө хэчнээн өлсөж байлаа ч дэргэдээ байгаа шувуутай хоолоо хувааж иддэг **жамтай**. Өгүүлбэрийн тодруулсан үгэнд тохирох үгийг олоорой. /1 оноо/
А. учиртай Б. Зайлшгүй В. ёстой Г.хэрэгтэй
4. Бүргэдийг шувуудын хаан гэж хэлсний учир юу вэ? /1оноо/
А. Хоолоо бусад шувуунд алдсан Б. Найз нөхөд ихтэй учраас
В. Ганцаараа амьдардаг тул Г. Бидний анд нөхөр учраас
- 5.”Хууль” гэдэг үгийн утгыг зөв тайлбарласан хэсгийг олоорой. / 1 оноо/
А. хуулж бичих Б.цаас хуйл В.хахууль өгөх Г. дүрэм журам
- 6.“**Туслах**” гэсэн үгийн ойролцоо утгыг бичнэ үү? /1 оноо/
А. дэмжих Б. өгөх В. өргөх г.түших
7. “**Гэмших** “ гэдэг үгтэй ижил дүрмээр бичигдсэн үгийг олоорой. /1 оноо/
А. Захих Б.Засрах В. гашилгах Г. харих
8. “Арилга” үгэнд я,е,ё алийг залгах вэ? тохирохыг сонгоорой. /1 оноо/
А. Гийгүүлэгчээр төгссөн үгэнд Я,Ё шууд залгана.
Б. Эгшиг болон зөөлний тэмдгээр төгссөн үгэнд Я,Ё шууд залгана.
В. Эгшиг болон зөөлний тэмдгээр төгссөн үгэнд Е шууд залгана.
9. ”Ээжийнхээ хэлсэн үгийг ангаахай сайтар бодсон..... тэднийг анд нөхрөө гэж санах болов.” гэсэн өгүүлбэрт тохирох холбоосыг тэмдэглээрэй. /1 оноо/
А. цаашилбал Б. ба
В. үүнээс болж Г. харин
10. “Би тэднийг өөрөө **дайлсан** юм. Тодруулсан үгэнд тохирох хэлц үгийг сонгоорой. /1оноо/
А. гэдэс гарах Б. аяганы амсар зуулгах В.гэдэс цадах Г. урьсан

